



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 5/07

Хэрлэн сум

Номын сангийн бүтэц орон тоог  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийтийн номын сангийн MNS5742:2019 стандартын дагуу орон тоо нэмэгдэх шаардлагатай болсон тул бүтэц орон тоог хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан бүтэц, орон тооны дагуу албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан баталж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийтийн номын сангийн захирлын үүргийг хавсран гүйцэтгэгч (Т.Отгонтуяа)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргыг үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн А/548 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
дүгээр сарын 22-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын зэрэглэл
1	Номын сангийн захирал	1	ТҮСБ-6
2	Сан хөмрөгч-нярав	1	ТҮСБ-4
3	Сүлжээний инженер, програмист	1	ТҮСБ-4
4	Бүртгэл мэдээллийн номын санч-Архив бичиг хэргийн ажилтан	1	ТҮСБ-4
5	Нийтийн уншлагын танхимын номын санч	1	ТҮСБ-3
6	Хүүхдийн уншлагын танхимын номын санч	1	ТҮСБ-3
7	Гэрээр ном олгох танхимын номын санч	1	ТҮСБ-3
8	Нягтлан бодогч	1	ТҮ-8
9	Сахиул -Үйлчлэгч	1	ТҮ-1
	Нийт	9	